



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/318

Алтай хот

Аймгийн Эрүүл мэндийн газрын
бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/37, А/38 дугаар тушаал, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн газрын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, орон тоог хоёрдугаар хавсралтаар, үйл ажиллагааны чиг үүргийг гуравдугаар хавсралтаар, дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Батлагдсан бүтэц, орон тооны дагуу төсөвтөө багтаан зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагаа явуулахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-г даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/278 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 438 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ



—000—

Аймгийн Засаг даргын 20²³ оны
05 дугаар сарын 24-ны өдрийн 1/318 дугаар
хоёрдугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Дарга	<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн асуудлаар Улсын их хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд шатны бусад байгууллагаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, хянах, тайлагнах -Нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн бодлого чиглэлээр хангах -Санхүүгийн болон хүний нөөцийн бодлого, эм хангамж, тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах -Байгууллагын төсвийн хөрөнгө, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, хяналт тавих -Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах -Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх үйл ажиллагааг бодлогоор хангах, хяналт тавих 	1

Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Хэлтсийн дарга	<ul style="list-style-type: none"> -Салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах -Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах -Байгууллага, хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах 	1
2	Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> -Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт -Эдийн засаг, шинжилгээ, үнэлгээ -Гүйцэтгэлийн санхүүжилт, үр дүнг тодорхойлох -Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл -Санхүүгийн тайлангийн нэгтгэл 	1
3	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> -Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт -Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал -Шагнал, урамшуулал -Сургалт, багц цагийн хэрэгжилт -Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгах 	1
4	Барилга байгууламж, тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> -Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа -Тээврийн хэрэгслийн бүртгэл, ашиглалт -Тоног төхөөрөмжийн ашиглалт, хангалт -Орон нутгийн өмчийн хамгаалалт -Худалдан авах ажиллагаа, гэрээлэлт 	1

5	Хууль, эрх зүйн зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн	-Хууль эрх зүйн зөвлөгөө, сургалт сурталчилгаа -Эрх бүхий албан тушаалтан -Тусгай зөвшөөрөл олгох, цуцлах -Өргөдөл гомдлын шийдвэрлэлт -Салбарын ёс зүйн асуудал	1
6	Даргын туслах	-Төлөвлөлт, тайлагналтын нэгтгэл -Шийдвэрийн хэрэгжилт -Хэвлэл, мэдээлэл, сурталчилгаа -Байгууллагын соёл -Дотоод ажил	1
7	Нягтлан бодогч	-Санхүү бүртгэл -Нягтлан бодох бүртгэл -Салбарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ -Татвар, нийгмийн даатгалын тайлан, тооцоо -Шилэн дансны хөтлөлт -Тайлагналт	1
8	Архив, бичиг хэргийн ажилтан	-Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивыг стандартын шаардлагад нийцүүлэн ажиллах -Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журмын талаар мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах, салбарын харъяа байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийг удирдан чиглүүлэх, -Эрүүл мэндийн салбарын АБЛЕ, Архив, И-оффисын програмуудыг ажилдаа мөрдлөг болгон интернетийн орчинд ажиллана. -Албан хэргийг хөтлөх, бүрдүүлэх, архивлах, хадгалах, хугацаанд нь шийдвэрлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах; -Ажлын төлөвлөгөөг жил, сараар гарган батлуулж, биелэлтийг сар, хагас болон бүтэн жилээр тайлагнах	1
9	Нярав	-Эм, эмнэлгийн хэрэгслийн түгээлт -Аж ахуйн хөрөнгийн хадгалалт, түгээлт, тооцоо -Үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэл	1
10	Жолооч	-Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах	2
11	Үйлчлэгч		1
12	Жижүүр		4
	Дүн		16

Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Хэлтсийн дарга	-Салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах -Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах -Байгууллага, хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах Эрүүл мэндийн дэмжих, салбар дундын хамтын ажиллагааг хангах	1
2	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	-Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	1
3	Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	-Халдварт өвчний бүртгэл мэдээлэл -Халдварт өвчний эрсдэлт хүчин зүйл, сэргийлэлт, эрт илрүүлэг -Халдварт өвчний тандалт, хяналт	1

4	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	-Халдварт бус өвчин түүний эрсдэлт хүчин зүйл, сэргийлэлт, эрт илрүүлэг -Хоол тэжээл, зохистой хооллолт -Сэтгэц, зан үйлийн эрүүл мэндийг хамгаалах -Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах -Осол гэмтэл -Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт	1
5	Эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	-Эрүүл мэндийн боловсрол -Мэдээлэл, сургалт, сурталчилгаа -Нийтэд түгээх эрүүл мэндийн мэдээллийн танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэх, нийтлэх -Олон нийттэй харилцах	1
6	Нөхөн үржихүйн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	-Нөхөн үржихүйн эрүүл мэнд -Жендэрийн асуудал -Хүчирхийллээс сэргийлэх -Өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд -Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	1
7	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн	-Дархлаажуулалтын төлөвлөлт, хамрагдалт, тайлагналт -Дархлаажуулалтын хангалт, нөөц, аюулгүй байдал, хяналт -Хүйтэн хэлхээ, тоног төхөөрөмжийн ашиглалт -Тарилгат халдварт өвчний тандалт, сэргийлэлт	1
8	Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн	-Уур амьсгалын өөрчлөлт -Агаарын бохирдол -Химийн хорт болон аюултай бодисоос сэргийлэх -Ус, хөрсний аюулгүй байдал -Ариутгал, халдваргүйтгэл -Хөдөлмөр, орчны аюулгүй байдал -Эмнэлгийн хатуу ба шингэн хог хаягдал	1
9	Нийгмийн эрүүл мэндийн эрүүл ноцтой байдал хариуцсан мэргэжилтэн	-Тандалт, сэргийлэлт, тархвар судлал -Гамшгийн эрсдэл, төлөвлөлт, тайлагналт -Хариу арга хэмжээ -Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа -Хүнсний аюулгүй байдал	1
Дүн			9

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Хэлтсийн дарга	-Салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах -Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах -Байгууллага, хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах -Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ	1
2	Хүүхдийн эрүүл мэндийн тусламж хариуцсан мэргэжилтэн	-Хүүхдийн тусламж үйлчилгээ	1
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого хариуцсан мэргэжилтэн	-Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, хүртээмж, чанар, аюулгүй байдал -Эмийн зохистой хэрэглээ, жор бичилт -Эмийн гаж нөлөө -Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, мэдээлэл, хяналт, тайлагналт -Эмийн худалдан авалт	1

4	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	-Магадлан итгэмжлэл -Эрсдэл, чанар -Яаралтай тусламж -Хэрэглэгчийн үнэлгээ -Эмнэлгийн дотоод халдвар -Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал -Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ	1
5	Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	-Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ -Сэргээн засах тусламж үйлчилгээ -Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээлэлт	1
6	Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	-Сувилахуйн тусламж үйлчилгээ	1
	Дүн		6

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Хэлтсийн дарга	-Салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах -Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах -Байгууллага, хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах -Хяналт-шинжилгээ, үнэлгээ	1
2	Эрүүл мэндийн статистик хариуцсан мэргэжилтэн	-Эрүүл мэндийн статистик -Мэдээ, мэдээлэл -Мэдээний сан	1
3	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	-Мэдээллийн технологи -Компьютер, техник хангамжийн засвар үйлчилгээ -Зайн анагаах ухаан	1
	Дүн		3

Хяналт, шалгалтын хэлтэс

№	Албан тушаалын нэр	Чиг үүрэг	Орон тоо
1	Хэлтсийн дарга	-Салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах -Хэлтсийн албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах -Байгууллага, хэлтсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах -Хяналт, шалгалт хийх	1
2	Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч	-Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх	1
3	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	-Халдвар судлалын хяналт шалгалт хийх -Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт шалгалт хийх -Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт шалгалт хийх	2
	Дүн		4
	Нийт орон тоо		39

Аймгийн Засаг даргын
2023 оны 05 сарын 21 өдрийн 318 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХЭЛТСИЙН ЧИГ ҮҮРЭГ

№	Нэгжийн нэр	Нэгжийн чиг үүрэг
1	Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс	<p>1.Аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Монгол улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэсэн эрүүл мэндийн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>2.Шийдвэр гаргахад Эрүүл мэндийн газрын даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>3.Цахим хуудсыг эрхлэн хөтлөх, олон нийтийн сүлжээг ашиглан байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах</p> <p>4.Салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ, үнэлгээ хийх, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хариуцах</p> <p>5.Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний бодлогыг төлөвлөх, нийгмийн асуудал, сургах, эмнэлгийн мэргэжилтнээр хангах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хэм хэмжээний талаар тодорхой арга хэмжээг зохион байгуулах</p> <p>6.Салбарын хөрөнгийн худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бүртгэх, тайлагнах, ашиглалтанд хяналт тавих</p> <p>7.Аймгийн эрүүл мэндийн салбарын эрх зүйн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах, туслалцаа үзүүлэх, Авлигаас ангид байх зарчмыг хэрэгжүүлэх</p> <p>8.Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах, тухайн шатны Засаг даргад танилцуулах, батламжлуулах</p> <p>9. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах</p>
2	Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	<p>1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд хамруулах, тандах тогтолцоог бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, түүнийг бууруулах, сэргийлэх, хүн амын өвөрмөц бүлгүүдийн эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан хөтөлбөр,</p>

		<p>стратеги боловсруулах, төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>2.Шийдвэр гаргахад Эрүүл мэндийн газрын даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>3.Нийгмийн эрүүл мэндийн онцгой нөхцөлийн тайван цагийн бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх, нийтийг хамарсан онцгой нөхцөл үүссэн үед эрүүл мэндийн бусад байгууллагуудтай харилцах, эрсдэлийн үеийн мэдээ мэдээлэл, харилцаа холбоо, хариу арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах, олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, салбар дундын шуурхай удирдлагын үйл ажиллагааг хангах</p> <p>4.Зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үнэлгээ хийх</p> <p>5.Дархлаажуулалтын үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, мэдээ мэдээллийг цуглуулах, тоон мэдээнд дүн шинжилгээ хийж тайлагнах;</p> <p>6.Нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр үе, залуучууд, хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орчны эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, хүн амд эрүүл мэндийн боловсролыг төлөвшүүлэх, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах</p> <p>7.Хүн амыг биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, эрүүл, зөв хооллолтыг дэмжих, эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх</p> <p>8.Эрүүл мэндийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах;</p>
3.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс	<p>1.Олон улсын чанарын шаардлагын түвшинд хүрсэн аюулгүй, хүртээмжтэй, чирэгдэлгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд үзүүлэх, орон нутгийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх,</p> <p>2.Өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар хөтөлбөр, стратеги боловсруулах, төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>3.Шийдвэр гаргахад Эрүүл мэндийн газрын даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах</p> <p>4.Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах тусламж, үйлчилгээг зохицуулах;</p> <p>5.Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагыг эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарсан стандарт, тусламж үйлчилгээний багц, удирдамжийн</p>

		<p>хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих, 7.Эмнэлгийн яаралтай тусламжийн холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхэд харьяа байгууллагуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах; 8.Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах; 9.Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хүртээмж, эмийн зохистой хэрэглээ, хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх</p>
4	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс</p>	<p>1.Монгол Улсын бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үе шат бүрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр хангах 2.Хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах. 3.Шийдвэр гаргахад Эрүүл мэндийн газрын даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах 4.Харьяа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн эргэн мэдээллээр хангах 5.Салбарын болон байгууллагын компьютерийн хэвийн аюулгүй ажиллагааг хангах, мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх, тоног төхөөрөмж, дотоод сүлжээний ашиглалтыг сайжруулах, 6.Мэдээллийн технологийн дэвшлийг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах.</p>
5	<p>Хяналт, шалгалтын хэлтэс</p>	<p>1.Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх 2.Эрүүл мэндийн тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих 3.Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоолт, усны чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангуулж байгаа эсэхэд хяналт тавих 4.Ус, хөрсөнд байгаа химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан эсэхэд хяналт тавих 5.Үйлдвэрлэл, сургалт, ахуйн хэрэглээ, гоо сайхны бараа, бүтээгдэхүүний чанарт хяналт тавих, 6.Хүнсний үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих</p>

7. Хүнсний бүтээгдэхүүнээс гарсан хордлого, халдварын шалтгааныг судлан тогтоох, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд дүгнэлт гаргах

8. Хүүхдийн сургалт, амралтын байгууллагын эрүүл ахуйн байдалд хяналт тавих

9. Эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгааллын дэглэм, тусгай, халдвартай, хортой, хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, устгалд хяналт тавих

10. Халдварт, халдварт бус өвчний талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

11. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтэд хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн бодис хэрэглэж буй эсэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийн хяналтын дотоодын байнгын тогтолцоо бий болгосон байдалд хяналт тавих

12. Хүнсний үйлдвэрлэлд ашиглах өсгөвөр, хүнсний нэмэлт, эм, даавар болон шавьж, мэрэгчийн устгалын хор, цацраг идэвхт бодист холбогдох байгууллагын дүгнэлт гаргуулсан байдалд хяналт тавих

Аймгийн Засаг даргын 20²³ оны
05 дугаар сарын 24-ны өдрийн 4318 дугаар
дөрөвдүгээр захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

Аймгийн Эрүүл мэндийн газар (цаашид Газар гэх) –ын бүрэн эрх, чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

Газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг мөрдлөг болгоно.

Газар нь иргэдээ дээдэлсэн, тэгш, хүртээмжтэй, чанартай, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

Газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар:

-Өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар, хөтөлбөр, стратеги, төлөвлөлт хийх, шийдвэр гаргахад аймгийн Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

-Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх эрүүл мэндийн үйл ажиллагаанд бусад салбар, иргэдийн оролцоог хангах;

-Хүн амын эрүүл мэндтэй холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал, шийдвэрийг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

-Эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд эмнэлгийн мэргэжилтний баримлах ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;

-Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах, шийдвэрлэх;

2.2. Эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар:

-Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах, тухайн шатны Засаг дагад танилцуулах, батламжлуулах;

-Харьяа нутаг дэвсгэрийн хүн амынхаа эрүүл эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, төрийн хүчин чадлаас давсан тусламж үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохицуулах, төлөвлөлт хийх;

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөрийн орон нутгаас тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага болон төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

2.3.Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих чиглэлээр:

-Эрүүл мэндийн байгууллагыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарсан стандарт, тусламж үйлчилгээний багц, удирдамжийн хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих;

-Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн нөлөөг судлах судалгаа хийх, зөвлөмж гаргах;

-Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах, хуваарилах;

-Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг санхүүгийн удирдлагаар хангах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн мэдээ, тайланг нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.4.Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх асуудлаар:

-Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход шаардлагатай мэдээ, мэдээллээр холбогдох байгууллагуудыг цаг тухайд нь шуурхай хангах;

-Өөрийн харьяа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр хангах;

Гурав. Удирдлага зохион байгуулалт

3.1.Аймгийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 6.6.3-д заасны дагуу эрх, үүргээ Эрүүл мэндийн газрын даргад шилжүүлж болно.

3.2.Төсвийн ерөнийлөн захирагч эрхээ шилжүүлэн ажилласнаар Төсвийн тухай хуулийн 22.6.5 заалтын дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ерөнхий менежертэй үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

3.3.Эрүүл мэндийн газар нь удирдлага санхүү, аж ахуйн хувьд бие даан ажиллах ба "Эрүүл мэндийн газар" гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, тамга хэрэглэнэ.

3.4. Эрүүл мэндийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж Засаг дарга, Эрүүл мэндийн сайдад тайлагнана.

3.5. Өөрийн бүтцэд Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийг байгуулан ажиллаж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаж, хяналт тавих.

3.6. Аймгийн Эрүүл мэндийн газрын орон тоог өөрийн орон нутгийн хүн ам, эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнээс хамааруулан тогтоож энэхүү дүрэм, үйл ажиллагааны чиглэлийг аймгийн Засаг даргын шийдвэрээр батална.

Дөрөв. Эрүүл мэндийн газрын эрх

4.1. Эрүүл мэндийн газрын эрх

- Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ.

- Харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн бүх эрүүл мэндийн байгууллагуудад хяналт-үнзлгээ хийх, хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үрэг, даалгавар өгч биелэлтийг шаардах, хариуцлага тооцох;

- Хүн амын эрүүл мэндийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих;

- Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх;

- Өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, ажилтнуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, урамшуулан дэмжих чиглэлээр төр олон нийт, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төрийн одон медаль, салбарын болон нутгийн захиргааны байгууллагын шагналд нэр дэвшүүлэх, шийдвэрлүүлэх;

- Өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагын үлгэрчилсэн бүтэц, дүрмийг батлах;

- Эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээрх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд зохион байгуулах, тус үйл ажиллагаанд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах;

- Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах;

- Эрүүл мэндийн чиглэлээр эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг зохион байгуулах;

- Эрүүл мэндийн байгууллагад гарсан шинэ бүтээл, дэвшилтэт технологид дүгнэлт гаргах, санал өгөх;

- Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийн байдалд хяналт тавих, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулан авах;

- Улсын байгцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх;

4.2. Эрүүл мэндийн газрын үүрэг

-Энэхүү дүрмийн 3.2-т заасны дагуу аймгийн Засаг дарга эрхээ шилжүүлсэн тохиолдолд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг Засаг даргын өмнө бүрэн хариуцах;

-Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн акт, стандарт, удирдамж, тусламж үйлчилгээний багц, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг хэрэгжүүлэх;

-Засаг даргаар ахлуулсан "Эрүүл мэндийн зөвлөл"-ийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж хурал зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн бэлтгэх;

-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэлээ тогтоож түншлэлийн чиглэл, хэтийн төлвийг тодорхойлох;

-Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

-Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамжтайгаар авч мэдээлэх, судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Албан бус төлбөрийг бууруулах, төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулж хяналт тавих;

-Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийн үнэлгээ болон эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

-Хүн амын өвчлөлийн чиг хандлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулж өөрийн орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх, харьяа эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн бүртгэлийн мэдээний санг байгуулах, тогтмол шинэчлэх;

-Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулах;

-Эм хангамжийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

-Харьяа эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, гүйцэтгэлийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

-Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцийн төлөвлөлт хийх;

-Харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хүний нөөцөөр хангах үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулах;

5.

-Өөрийн орон нутагт явуулж эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчинг бүрдүүлэх, сургалт зохион байгуулах нөхцөлөөр хангах;

-Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг зохион байгуулах;

-Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа догодлыг бүртгэн мэдээлэх;

-Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах хянах, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага мөн.

-Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, стратегийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг зохион байгуулна.

-Зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үнэлгээ хийх, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааг дангаараа болон бусад эмнэлэг мэргэжлийн төвүүд, салбар аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт иргэдтэй хамтран аймгийн түвшинд зохион байгуулна.

-Хүн амын дундах өвчлөлийг тандах, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж эмчлэн эдгэрүүлэх үйл ажиллагааг харьяа орон нутгийн эмнэлгийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

-Хүн амын дунд биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр чийрэгжих, эрүүл зөв хоололтыг дэмжих, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр чийрэгжүүлэлтийн, хоол зүй, сэтгэл зүй, донтолт, хүчирхийллийн эсрэг зөвөлгөө өгөх болон өсвөр үе өхмадын эрүүл мэндийн нэгжийг байгуулан ажиллаж болно.

-Халдварт болон халдварт бус өвчин болон хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийн талаар тандалт судалгаа хийж, мэдээний сан байгуулан ажиллана.

-Хяналт шалгалтын бодлого, төлөвлөлтийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх;

__оОо__

شعبه - هیئت مدیره
 هیئت مدیره (مدیران)



تاریخ: ...

مجلس

شماره ...
 تاریخ ...

اجتناباً از ...
 ...

این هیئت مدیره ...
 ...
 ...

6 ...
 ...
 ...

7 ...
 ...
 ...

8 ...
 ...
 ...



...
 ...

0291160020

